

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн  
2018 оны санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** САГ-2019/101/СТА-ТӨХК

## АГУУЛГА

1.	Аудитын гэрчилгээ.....	4
1.	Аудитын гэрчилгээ.....	5
2.	Аудитын тайлан .....	7
2.1.	Оршил.....	7
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	7
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	8
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	8
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	10
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	10
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	11
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	11
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	12
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	12
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга.....	12
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	12
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3.	Менежментийн захидал .....	14
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	16

## Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ААНОАТ	Аж ахуйн нэгжиний орлогын албан татвар
ТӨХК	Төрийн өмчийн хувьцаат компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ  
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.НЯМСАМБУУ  
ТАНАА

2019.03.15 № 06/464  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай, нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 18-наас 2019 оны 3 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Грант Торнтон аудит” ХХК-ийн ахлах аудитор Л.Болорцэцэг, бүртгэл санхүүгийн ахлах мэргэжилтэн Ш.Оюунчимэг, мэргэжилтэн Б.Солонготуяа нар хэрэгжүүлэв.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01/214 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи ашиглан цахилгаан эрчим хүчийг үр ашигтай дамжуулна. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрчим хүчний салбарын аюулгүй, найдвартай ажиллагаа, үр ашигтай байдлыг хангах,
- Эрчим хүчний хангамжийн тасралтгүй, найдвартай аюулгүй байдлыг хангах,
- Техникийн найдвартай ажиллагааг ханган, дэвшилтэт техник технологи, оновчтой шийдлийг шинээр нэвтрүүлэх, эдийн засгийн үр ашгийн дээшлүүлэх,



- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд өргөтгөл, шинэчлэлтийн ажил хийх,
- Аюулгүй ажиллагааг эрхэмлэх
- Эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, шугам сүлжээ байгуулах,
- Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан дамжуулах сүлжээ, дэд станцыг барьж байгуулах явдал байна.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд::

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль
- Цахилгаан, дулааны эрчим хүч, нүүрсний төлбөрийн тухай
- Агаарын бохирдлын хөтөлбөрийн тухай
- Агаарын тухай
- Барилгын тухай
- Компанийн тухай
- Галын аюулгүй байдлын тухай
- Татварын ерөнхий хууль
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- 2018 оны 6 дугаар сарын 7-нд Төсвийн тухай хуулийн 24.4-д “Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ”, 24.1-д “Төсвийн зарлага нь урсгал болон хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн нийлбэрээс бүрдэнэ” тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байна.
- 2018 оны 1 дүгээр сарын 12-нд Агаарын бохирдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг

*тайлагнах үүрэг бүхий албыг байгуулж ажиллуулна”, 29 дүгээр зүйл “Агаарын бохирдлын эсрэг сан” 29.1-д “Агаарын бохирдлын эсрэг сан /цаашид “сан” гэх/гийн үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна”, 29.2-д “Сангийн төсвийн ерөнхийлөн захирагч нь байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна”, 29.3-д “Сан нь түүний үйл ажиллагааг удирдан чиглүүлэх орон тооны бус Удирдах зөвлөлтэй байна”, 29.4-д Энэ хуулийн 29.3-т заасан Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайд томилно, 29.5-д “Энэ хуулийн 29<sup>1</sup>.3-т заасан Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална” 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “Мэргэжлийн алба” гэснийг “бүх шатны Засаг дарга мэргэжлийн албатай хамтран” гэж тус тус өөрчлөлт орсон байна.*

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус компанийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого журамтай нийцсэн байна.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Даймонд” програм хангамж ашигладаг байна.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг гүйцэтгэх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.



Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгох болсон шалтгаан нь байгууллагын тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц гэж үзсэн. Нийт хөрөнгийн дүнгээс тооцоход их байгаатай холбоотой юм.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны нийт зардал 19,945.7 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 199.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

*Нийт зардлыг* материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тооцох хувийг 1 хувиар тооцсон нь Материаллаг байдлын суурийг тооцоходоо нийт зардлыг суурь болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг гүйцэтгэх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	12.7	Найдваргүй авлагын нөөц байгуулах, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах зөвлөмж өгөв.
	Дүн	3	12.7	

### **2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулан тэмдэглэв.

### **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 88 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 4 дүгээр сарын 09-ний 57 дугаар тушаал, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 21 дугаар тогтоолыг тус тус үндэслэн арилжааны банкуудын зээлийн хүүг судлан Голомт банкттай 17,000.0 сая төгрөгийн зээлийн гэрээ байгуулсан байна. Энэхүү зээлээр бүтээн байгуулсан хөрөнгө, түүний гүйцэтгэл, эцсийн шийдвэрийг нягтлан шалгах, төсөл хөтөлбөрөөр гүйцэтгэж байгаа ажлын үр дүн гүйцэтгэлийн талаар дараагийн аудитад хамруулан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь тайланд Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу тус компанийн гүйцэтгэх захиралын 2018 оны 2 дугаар сарын 2-ны А/18 дугаар тушаалаар хөрөнгийн үнэлгээний гүйцэтгэх ажлыг 4 хүний багийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж нийт 975306.5 мкв газрыг 28,776.6 сая төгрөг, 170 ширхэг барилгыг 4,237.6 сая төгрөг, 49 ширхэг нийтийн эзэмшлийн байгууламжийг 89.9 сая төгрөг нийт **4,327.6** сая төгрөгөөр үнэлж, Монгол улсын тэргүүлэх зэргийн үнэлгээчин Ц.Сэржээ нягтлан шалгалтаар баталгаажуулсан байна. Дахин үнэлэгдсэн дээрх хөрөнгийн дүнг данс бүртгэлд бүртгэн авч, санхүүгийн тайланд тайлагнасан байна.

### **2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төрийн өмчит байгууллагын удирдлага нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой арга хэмжээнд зориулан 2018 онд 344,905.6 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 348,513.1 сая төгрөг буюу 101 хувьтай байгаа нь "Оюутолгой" ХХК-тай байгуулсан цахилгаан эрчим хүч хадгалах, худалдан авах гэрээний дагуу тооцсон зардал 292,004.2 сая төгрөгийг бүртгэсэнээр нийт зардал төсөвлөснөөс 6,249.8 сая төгрөгөөр хэтэрч, нөгөө талдаа нийт орлого өссөн үзүүлэлттэй харагдаж байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn/](http://www.shilendans.gov.mn/) цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2018 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг тоо мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгснөөс 100 хувь хэрэгжүүлж биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдөр 01/989 дугаар албан бичгийн хамт Үндэсний аудитын газарт хүргүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүү байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан, тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1. Балансын данстай холбоотой асуудал

##### 3.1.1. Илрүүлэлт:

Компани нь авлагын насжилтын тайлан бэлтгэдэггүй, найдваргүй авлагын нөөц байгуулдаггүй нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 9.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд бүртгэнэ"*; НБББББ-т *"Найдваргүй авлагын нөөцийг тооцох хувь хэмжээ, насжилтын интервалыг тодорхой судлагаанд суурилж, компанийн гүйцэтгэх захиралын баталсан тусдаа журмаар зохицуулна, мөн авлага, өглөгийн тооцоог хариуцсан нягтлан бодогч авлага, өглөгийн тайлантай харьцуулан дансны авлага, өглөгийн хооронд суутган тооцож болох үлдэгдэл байгаа эсэхийг хянаж, ерөнхий нягтлан бодогчид мэдэгдэнэ"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

“Тавин лан” ХХК-тай байгуулсан гэрээт ажлын хүрээнд шатахууны зардал болох 12.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагыг он дамжуулан бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 14.2.3-д *"Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"*; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.-д *"Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* заалттай нийцэхгүй байна.

### 3.1.2. Эрсдэл:

Бодлого журам хэрэгжихгүй байх, найдваргүй авлага бий болох, эрх ба үүрэг, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байх

### 3.1.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд авлагыг бодит үнэ цэнээр үнэлж бүртгэх, авлага барагдуулахад анхаарч ажиллах. Компани найдваргүй авлагын нөөц байгуулахдаа орлогын болон авлагын аргуудаас сонгон ашиглах, хуулиар хүлээсэн үүрэг, гэрээний үүргийн биелэлтийг тус тус хангаж, ажил үйлчилгээг тухай бүр хүлээлцэх, авлага барагдуулах арга хэмжээг авч, үргүй зардал гаргахгүй байх зөвлөмж өгөх.

### 3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Найдваргүй авлага үүсэх магадлал бага байдаг бөгөөд цаашид зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэн ажиллана.

## 3.2. Санхүүгийн програмтай холбоотой асуудал

### 3.2.1. Илрүүлэлт:

Компанийн санхүү бүртгэлд ашиглаж буй "Даймонд" санхүүгийн програм нь ерөнхий журналын гүйлгээний жагсаалтын харилцагчийн нэр, харилцагчийн код гардаггүй, байгаа нь хөндлөнгийн шалгалт хийхэд хүндрэлтэй байна.

### 3.2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт, авлага, өглөгийн харилцагчийн бүртгэлийг зөрүүтэй, алдаатай бэлтгэх.

### 3.2.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн програм хангамжийг сайжруулж, өргөтгөл шинэчлэлийг цаг тухай бүр нь бэлтгэн нийлүүлэгч компаниар хийлгүүлэх, талаар зөвлөмж өгөх.

### 3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хүлээн авч, холбогдох газартай хамтран ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	01/01/2018	31/12/2018
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,084,060,995.28	6,064,350,439.04
1.1.2	Дансны авлага	2,842,554,563.32	2,530,039,234.27
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	73,206,450.29	237,775,834.33
1.1.4	Бусад авлага	1,328,937,832.47	671,760,052.84
1.1.6	Бараа материал	5,937,458,795.27	5,732,618,186.66
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	1,909,761,719.37	12,818,482,983.36
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>15,175,980,356.00</b>	<b>28,055,026,730.50</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	315,877,447,673.71	346,526,324,288.00
1.2.2	Биет бус хөрөнгө	762,484,728.49	29,490,184,982.42
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,252,398,087.68	1,186,482,398.90
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	3,095,708,961.49	1,523,910,607.00
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>320,988,039,451.37</b>	<b>378,726,902,276.32</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>336,164,019,807.37</b>	<b>406,781,929,006.82</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	978,425.50	-
2.1.1.3	Татварын өр	36,470,251.83	484,203.67
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	528,589.05
2.1.1.5	Богино хугацаат зээл	1,441,654,346.44	14,004,218,618.36
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,811,084,269.38	3,136,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	620,502,805.02	1,359,327,377.61
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>3,910,690,098.17</b>	<b>15,367,694,788.69</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	17,959,568,870.75	16,497,493,802.39
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	450,311,032.75	450,311,032.75
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	52,134,939,646.05	79,985,910,106.00
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>70,544,819,549.55</b>	<b>96,933,714,941.14</b>



1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (үргэлжлэл...)

СТ-1А

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	01/01/2018	31/12/2018
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>74,455,509,647.72</b>	<b>112,301,409,729.83</b>
2.3.1	Төрийн өмч	238,073,068,351.04	238,073,068,351.04
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	42,559,249,380.19	46,727,970,456.22
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	34,108,978.94	28,810,767,698.94
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(18,957,916,550.52)	(19,131,287,229.21)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>261,708,510,159.65</b>	<b>294,480,519,276.99</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>336,164,019,807.37</b>	<b>406,781,929,006.82</b>

4.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

СТА-2А

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>154,307,993,349.80</b>	<b>337,448,162,079.93</b>
2	Борлуулалтын өртөг	150,483,636,671.16	328,559,682,024.84
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>3,824,356,678.64</b>	<b>8,888,957,555.09</b>
4	Түрээсийн орлого	12,586,143.76	32,214,946.28
5	Хүүгийн орлого	395,529,424.40	468,776,275.36
8	Бусад орлого	4,775,617,790.90	10,600,838,687.83
9	Борлуулалт, маркетингийн зардал	8,164,436.36	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	4,808,217,841.80	9,599,278,278.58
11	Санхүүгийн зардал	218,765,395.32	204,851,656.11
12	Бусад зардал	3,808,176,526.93	9,275,101,214.93
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	(9,291,419.15)	2,405,553.52
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	(82,806,804.69)	(866,478,132.58)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>72,667,613.45</b>	<b>47,006,235.88</b>
19	Орлогын татварын зардал	39,552,942.44	46,877,627.52
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>33,114,671.01</b>	<b>128,608.36</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>33,114,671.01</b>	<b>128,608.36</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>33,114,671.01</b>	<b>128,608.36</b>

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТА-3А

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>65,831,039,078.32</b>	<b>115,093,125,058.02</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	42,043,737,814.55	49,085,945,880.81
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	205,788,033.95	312,924,716.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	23,581,513,229.82	65,694,254,461.21
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>68,823,151,953.92</b>	<b>109,790,937,857.74</b>
1.2.1	Ажилагсад төлсөн	18,982,261,344.36	20,132,117,494.49
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,184,828,182.08	5,995,754,916.73
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,013,352,785.40	2,890,803,314.99
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	277,059,747.46	265,850,057.29
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,087,783,368.54	1,114,081,154.08
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	10,113,956.73	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	22,620,518,310.91	42,664,500,835.57
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	50,753,830.00	21,153,532.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	16,596,480,428.44	36,706,676,552.59
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(2,992,112,875.60)</b>	<b>5,302,187,200.28</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>403,005,389.32</b>	<b>471,881,529.63</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	7,350,000.00	3,150,000.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	75,460.00	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	395,579,929.32	468,731,529.63
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,198,481,778.27</b>	<b>2,597,021,315.75</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,142,806,403.27	2,553,389,578.75
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	36,684,800.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	16,246,800.00	6,946,937.00

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл...)

СТА-3А

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	39,428,575.00	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,795,476,388.95)</b>	<b>(2,125,139,786.12)</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>32,748,960.79</b>	<b>37,452,830.62</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	34,625,928.52
3.1.3	Төрөл бүрийн хандив	30,200,000.00	-
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	2,548,960.79	2,826,902.10
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>208,783,127.62</b>	<b>234,210,801.02</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	196,942,747.68	233,789,452.44
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	11,840,379.94	421,348.58
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(176,034,166.83)</b>	<b>(196,757,970.40)</b>
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(4,963,623,431.38)	2,980,289,443.76
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,047,684,426.66	3,084,060,995.28
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,084,060,995.28	6,064,350,439.04

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТА-4А

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>228,017,764,005.22</b>	<b>42,651,303,717.99</b>	<b>10,196,671,750.08</b>	<b>(18,355,510,796.55)</b>	<b>262,510,228,676.71</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(635,520,424.98)	(635,520,424.98)
3	Залруулсан үлдэгдэл	227,910,505,579.90	42,650,402,553.09	10,196,671,750.08	(18,991,031,221.53)	261,874,708,251.76
5	Өмчид гаргасан өөрчлөлт	10,055,304,345.82	-	(10,162,562,771.14)	-	(107,258,425.32)
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	33,114,671.01	33,114,671.01
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(92,054,337.80)	-	-	(92,054,337.80)
9	<b>2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>238,073,068,351.04</b>	<b>42,559,249,380.19</b>	<b>34,108,978.94</b>	<b>(18,957,916,550.52)</b>	<b>261,708,510,159.65</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(173,499,287.05)	(173,499,287.05)
11	Залруулсан үлдэгдэл	238,073,068,351.04	42,559,249,380.19	34,108,978.94	(19,131,415,837.57)	261,535,010,872.60
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
13	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	28,776,658,720.00	-	28,776,658,720.00
15	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	128,608.36	128,608.36
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн (өсөлт)	-	4,327,600,028.33	-	-	4,327,600,028.33
	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн (бууралт)	-	(158,871,962.20)	-	-	(158,871,962.20)
17	<b>2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>238,073,068,351.04</b>	<b>46,727,970,456.22</b>	<b>28,810,767,698.94</b>	<b>(19,131,287,229.21)</b>	<b>294,480,519,276.99</b>

#### 4.5. Аудит хийсэн зорилтот түвшингийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(сая төгрөгөөр)

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 оны		Харьцуулалт		
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2017-2018 оны гүйцэтгэл	Төлөвлөгөө, гүйцэтгэл 2018 он	
<b>А. Санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд</b>									
1	<b>Нийт орлого</b>		<b>сая.төг</b>	<b>159,505.60</b>	<b>344,905.58</b>	<b>348,560.14</b>	<b>189,054.54</b>	<b>3,654.56</b>	<b>101</b>
	Борлуулалтын орлого	Бичилт	сая.төг	154,308.00	46,363.61	45,443.98	(108,864.02)	(919.63)	98
	ОТ ЦЭХ худалдах, худалдан авах гэрээний дагуу		сая.төг	-	285,754.35	292,004.18	292,004.18	6,249.83	102
	Үйл ажиллагааны бус орлого		сая.төг	5,197.60	12,787.62	11,111.97	5,914.37	(1,675.65)	87
2	<b>Нийт зардал</b>		<b>сая.төг</b>	<b>159,433.00</b>	<b>344,905.58</b>	<b>348,513.13</b>	<b>189,080.13</b>	<b>3,607.55</b>	<b>101</b>
	Үйл ажиллагааны зардал		сая.төг	155,300.00	46,643.03	46,359.63	(108,940.37)	(283.40)	
	“Оюутолгой” ХХК-тай ЦЭХ худалдах, худалдан авах гэрээний дагуу		сая.төг	-	285,754.35	292,004.18	292,004.18	6,249.83	102
	Үйл ажиллагааны бус зардал		сая.төг	4,133.00	12,508.20	10,149.32	6,016.32	(2,358.88)	
4	<b>Татварын өмнөх ашиг, алдагдал</b>		<b>сая.төг</b>	<b>72.60</b>	<b>-</b>	<b>47.01</b>	<b>(25.59)</b>	<b>47.01</b>	
5	<b>Орлогын албан татварт</b>		<b>сая.төг</b>	<b>39.60</b>	<b>-</b>	<b>46.88</b>	<b>7.28</b>	<b>46.88</b>	
6	<b>Татварын дараах ашиг, алдагдал</b>		<b>сая.төг</b>	<b>33.00</b>	<b>-</b>	<b>0.13</b>	<b>(32.87)</b>	<b>0.13</b>	
7	<b>Нийт авлага</b>		<b>сая.төг</b>	<b>5,497.10</b>	<b>19,436.90</b>	<b>21,835.90</b>	<b>16,338.80</b>	<b>2,399.10</b>	112
	Үүнээс:	БХА	сая.төг	4,244.70	1,065.20	3,439.60	(805.10)	2,374.40	323
		УХА	сая.төг	1,252.40	1,161.80	1,186.50	(65.90)	24.60	102
		Улсын төсвөөс	сая.төг	-	17,209.90	17,209.90	17,209.90	-	100
8	<b>Нийт өглөг</b>		<b>сая.төг</b>	<b>22,320.60</b>	<b>37,495.57</b>	<b>32,315.50</b>	<b>9,994.90</b>	<b>(5,180.07)</b>	86
	Үүнээс:	УХӨТ	сая.төг	18,409.90	17,986.60	16,947.80	(1,462.10)	(1,038.76)	94
		БХӨТ	сая.төг	3,910.70	2,299.14	2,772.08	(1,138.62)	472.94	121
		Банкны зээл	сая.төг	-	17,209.86	12,595.61	12,595.61	(4,614.25)	73
9	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		<b>сая.төг</b>	<b>15,176.00</b>	<b>15,175.98</b>	<b>31,557.34</b>	<b>16,381.34</b>	<b>16,381.36</b>	
10	<b>Эргэлтийн бус хөрөнгө / Үндсэн хөрөнгө /</b>		<b>сая.төг</b>	<b>317,892.40</b>	<b>320,988.04</b>	<b>378,726.90</b>	<b>60,834.50</b>	<b>57,738.86</b>	
	Үүнээс: Үйлдвэрлэлийн		сая.төг	311,438.70	312,677.95	341,794.13	30,355.43	29,116.18	
	Ерөнхий хэрэглээний		сая.төг	4,438.80	4,451.90	5,918.68	1,479.88	1,466.79	
	Бусад		сая.төг	762.50	762.48	29,490.18	28,727.68	28,727.70	
	Бусад эргэлтийн бус хөрөнгө		сая.төг	1,252.40	3,095.71	1,523.91	271.51	(1,571.80)	
11	Нийт ажиллагсад		тоо	1,142.00	1,176.00	1,154.00	12.00	(22.00)	
12	Цалингийн сан		сая.төг	20,925.10	22,910.26	22,717.05	1,791.95	(193.21)	
13	<b>Дундаж цалин</b>		<b>төгрөг</b>	<b>1,526,931.00</b>	<b>1,623,459.19</b>	<b>1,640,457.00</b>	<b>113,526.00</b>	<b>16,997.81</b>	
	Үүнээс:	Удирдлага	төгрөг	4,385,511.00	5,010,033.97	5,524,063.56	1,138,552.56	514,029.59	
		ИТА	төгрөг	1,709,259.00	1,808,575.02	1,884,890.36	175,631.36	76,315.34	
		Ажилчид	төгрөг	1,305,057.00	1,398,285.14	1,363,549.40	58,492.40	(34,735.74)	



4.6. Аудит хийсэн зорилтот түвшиний тайлан (үргэлжлэл....)

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 оны		Харьцуулалт		
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2017-2018 оны гүйцэтгэл	Төлөвлөгөө, гүйцэтгэл 2018 он	
<b>Б. Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд</b>								
<b>14</b>	<b>Дамжуулах ЦЭХ</b>	<b>мян.кВтц</b>	<b>5,171,262.40</b>	<b>5,378,424.46</b>	<b>5,652,287.02</b>	<b>481,024.62</b>	<b>273,862.56</b>	
15	Дамжуулалтын алдагдал	Биет	мян.кВтц	173,399.00	182,974.48	178,090.16	4,691.16	(4,884.33)
		Хувь	%	0.03	0.03	0.03	(0.00)	(0.00)
	Үүнээс: техникийн алдагдал	Биетээр	мян.кВтц	160,437.30	166,970.36	165,313.48	4,876.18	(1,656.88)
		Хувиар	%	0.03	0.03	0.03	(0.00)	(0.00)
	Дотоод хэрэглээ	Биетээр	мян.кВтц	12,961.80	16,004.12	12,776.67	(185.13)	(3,227.45)
Хувиар		хувь	0.00	0.00	0.00	(0.00)	(0.00)	
<b>16</b>	<b>Дамжуулсан ЦЭХ</b>	<b>мян.кВтц</b>	<b>4,997,863.40</b>	<b>5,195,449.97</b>	<b>5,474,196.86</b>	<b>476,333.46</b>	<b>278,746.89</b>	
17	Борлуулсан цахилгааны дундаж тариф	төг/кВтц	30.87	8.92	8.30	(22.57)	(0.62)	
18	Их засвар хийсэн тоноглол		тоо	276.00	305.00	292.00	16.00	(13.00)
	Үүнээс:	Үндсэн	тоо	-	-	-	-	-
		Туслах	тоо	-	-	-	-	-
19	Их засварт зарцуулсан хөрөнгө		сая.төг	1,772.00	2,574.52	2,182.84	410.84	(391.68)
	Үүнээс:	Үндсэн	сая.төг	-	-	-	-	-
		Туслах	сая.төг	-	-	-	-	-
		Бусад	сая.төг	-	-	-	-	-
20	ТЗБАХ-нд зарцуулсан хөрөнгө		сая.төг	8,798.70	6,677.67	4,656.62	(4,142.08)	(2,021.06)
	Гүйцэтгэсэн ажил		тоо	57.00	90.00	74.00	17.00	(16.00)
21	Хөрөнгө оруулалтанд зарцуулсан хөрөнгө		сая.төг	1,411.50	2,057.19	1,962.15	550.65	(95.03)
	Гүйцэтгэсэн ажил		тоо	44.00	146.00	136.00	92.00	(10.00)
22	2017 онд батлагдсан он дамжиж хийсэн ажлууд		сая.төг			1,834.33	1,834.33	1,834.33

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	<b>2018 он</b>	<b>Аудитын нэр:</b>	<b>Санхүүгийн тайлангийн аудит</b>	<b>Аудитын код:</b>	САГ-2019/101/СТА-ТӨХК
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>		<b>“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК</b>			<b>сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог нэр
<b>А</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1	Компани нь авлагын насжилтын тайланг бэлтгэдэггүй, найдваргүй авлагын нөөц байгуулдаггүй,		Зөвлөмж өгөх	Санхүү албаны дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Энхмаа Э.Түмэнжаргал
	Гэрээний хугацаа дууссан 12.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагыг он дамжуулан бүртгэж, авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.	12.6	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал  Санхүү албаны дарга  Ерөнхий нягтлан бодогч	Б.Нямсамбуу  Б.Энхмаа Э.Түмэнжаргал
2	Компанийн санхүү бүртгэлд ашиглаж буй "Даймонд" санхүүгийн програм нь ерөнхий журналын гүйлгээний жагсаалтын харилцагчийн нэр, харилцагчийн код гардаггүй, байгаа нь хөндлөнгийн шалгалт хийхэд хүндрэлтэй байна.		Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Санхүү албаны дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Нямсамбуу Б.Энхмаа Э.Түмэнжаргал
<b>Нийт дүн</b>		<b>12.6</b>			



